



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 8/136

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг дэмжих, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хавсралтад нэр дурдагдсан сууц өмчлөгчдийн холбоодын харьяалах 1 дүгээр хорооны 3, 4 дүгээр байр, 2 дугаар хорооны 3, 8, 9, 14 дүгээр байрны дээврийн засварын ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Төсвийг хавсралтаар баталж, засварын ажилд шаардагдах 3,752,000 (гурван сая долоон зуун тавин хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3. Оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг хангах ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, дууссанаас хойш 14 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Хангайн өргөө сууц өмчлөгчдийн холбоо (Д.Бужигдай)-нд, Их хангай сууц өмчлөгчдийн холбоо (З.Нармандах)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн
41/36 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



2 ДУГААР ХОРООНЫ ИХ ХАНГАЙ СӨХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Чулуутай хар цаас	Боодол	10	115,000	1,150,000
2	Чулуугүй хар цаас	Боодол	2	125,000	250,000
3	Мастика	Лааз	2	110,000	220,000
Нийт					1,620,000

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны дугаар сарын-ны өдрийн
8/136 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



1 ДҮГЭЭР ХОРООНЫ ХАНГАЙН ӨРГӨӨ СӨХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цемент	ш	10	20,000	200,000
2	Праймер (1 сав 18 литр)	Лааз	4	123,000	492,000
3	Чулуутай хар цаас Техноникель	Боодол	6	115,000	690,000
4	Чулуугүй хар цаас BLG Техноникель	Боодол	6	125,000	750,000
Нийт					2,132,000